

## ГЕРМАНЫ «ВОСТВАГ» ХУВЬЦААТ НИЙГЭМЛЭГ, ТҮҮНИЙ МОНГОЛ ДАХЬ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Д.Уламбаяр\*

### Товч утга:

1920-30-аад онд Монголд үйл ажиллагаа явуулж байсан Германы «Востваг» хувьцаат нийгэмлэг, түүний үйл ажиллагаа, энэ байгууллагын үйл ажиллагаанд ЗХУ-ын ДЯЯ хэрхэн оролцож байсан, «Востваг» хувьцаат нийгэмлэгийн Монголын гадаад худалдаа, эдийн засагт үзүүлж байсан үр нөлөө, тус нийгэмлэгийн цаашдын хувь заяа хэрхсэн талаар архивын баримтад тулгуурлан өгүүлнэ.

**Түлхүүр үг:** «Востваг», ногдол ашиг, гадаад худалдаа, худалдааны төлөөлөгч, худалдааны хөдөлгөөнт сүлжээ, райхсмарк, алтан рубль, улаан армийн IV газар, тусгай алба, de facto, ad hoc.

**Б**ХК(б)Н-ын шууд удирдлага, санхүүжилтээр баттай оршин тогтнож байсан Коминтерн гэх энэ байгууллага дэлхийд большевик хувьсгалыг өрнүүлэх, «хувьсгалт дипломат» ажиллагаа, тагнан турших хууль бус үйл ажиллагаа явуулж, улс орнуудын дотоод хэрэгт хөндлөнгөөс эрээ цээргүй оролцож, дээрээс бодлогоор улс төрийн аллага зохион байгуулж байсан бөгөөд 1930-аад оны эхнээс энэ байгууллагын үүрэг эрс буурч, харин ЗХУ-д Сталинийг тахин шүтэх ажиллагааг дээрээс бодлогоор зохион байгуулж, ДЯЯ-ны үүрэг үлэмж өргөжсөн билээ.

Коминтерний шууд удирдлага дор 1928 оны 10-12 дугаар сард хуралдсан МАХН-ын VII их хурал Ц.Дамбадорж, Н.Жадамба, А.Амар, профессор Ж.Цэвээн, Ц.Дашсампилон зэрэг улс төрийн олон удирдагчдыг хөрөнгөтөн орнуудтай дотносох гэсэн, «Баяжигтун» лозунг санаачлагч, ЗХУ-аас хөндийрөх гэсэн гэж хурц шүүмжлээд «Баруунтан» хэмээн цоллож, намын удирдлагаас гаргасан байна. Их хурлын дараа «Баруунтныг» илчлэх, намыг

\*Д.Уламбаяр - ХИС-ийн Олон улс судлалын сургалт-судалгааны төмийн захирал доктор (Ph.D), профессор

цэвэрлэх өргөн хэмжээний кампанит ажил өрнөж гадаадын иргэд, капиталыг Монгол Улсаас дэс дараатай шахан гаргаж эхэлжээ. БХК(б)Н, Коминтерн болон зүүнтний ажил явуулгын үрээр Монгол Улсын Засгийн газар 1930 оны 12 дугаар сард гадаад худалдаанд улсын онц хэрэг тогтоосноор Монгол Улсын эдийн засаг дан гагц нэг орноос хамааралтай болохын эх үндэс тавигдаж Зөвлөлтийн тойрог замд орсноор дагуул улс болов. Гадаад худалдаанд улсын онц эрх тогтсоноор гадаадын компаниуд тус улсад үйл ажиллагаа явуулах ямар ч бололцоогүй болж, Монголын эдийн засгаас шахагдан гарчээ. Гадаад худалдаанд улс монополь эрх тогтоосон нь 1929 оны 6 дугаар сарын 25-нд Улаанбаатарт гарын үсэг зурсан **«Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Холбоот Улс ба БНМАУ хоёрын хоорондын үндсэн зүйлүүдийг батлан тогтоосон Гэрээ бичиг»** хэмээх маш нууц [зэрэглэлтэй Д.У] хэлэлцээртэй шууд холбоотой байв. Гэрээ бичигт:

**«СССР нь Монголыг, Монгол нь СССР-ийг ийнхүү онцоор үзсэн лүгээ адил бусад гадаад улсыг үзэх болсон нь хоёр этгээдийн уул бодлого зорилго лугаа үл нийцэх тул аливаа гадаад улсууд ба тэр улсуудын харъяат нарт тийнхүү онцоор үзэх явдлыг үл дэлгэрүүлэхийг хоёр этгээдээс батална»**<sup>1</sup> гээд БНМАУ нь зөвхөн ЗХУ-д бараа бүтээгдэхүүнээ экспортлож, зөвхөн ЗХУ-аас бараа, бүтээгдэхүүн импортлох, ЗХУ-д үйлдвэрлэдэггүй бүтээгдэхүүнийг зөвхөн ЗХУ-ын нутгаар дамжуулан оруулж байхаар заасан байна.<sup>2</sup> Энэ хэлэлцээрт анх удаа Зөвлөлтийн сургагч, зөвлөхүүдийн тухай тусгагджээ. Дурдсан хэлэлцээрт Монголын талаас Ерөнхий сайдын жинхэнэ орлогч бөгөөд ААЯ-ны сайд Ж. Дамдинсүрэн, ГЯЯ-ны сайд Ц. Гүрсэд, УБХ-ын гишүүн П. Гэндэн, Зөвлөлтийн талаас Бүрэн эрх барих Элчин төлөөлөгч А.Я. Охтин, ЗХУ-аас БНМАУ-д суугаа худалдааны төлөөлөгч Ефим Григорьевич Ботвиник, ЭСЯ-ны 1 дүгээр нарийн бичгийн дарга А.Климов нар гарын үсэг зуржээ. Улмаар Коминтерн, ЗХУ-ын шахалтаар сайхь хэлэлцээрийг үндэслэн БНМАУ-ын Засгийн газар 1930 оны 12 дугаар сард гадаад худалдаанд улсын онц эрх тогтоосноор Монголоос гадаадын пүүс, капитал бүрмөсөн шахагдан гарсан байна. Энд Монголын зах зээлийг ямарч өрсөлдөөнгүй дангаар эзэгнэх гэсэн ЗХУ-ын геоэдийн засгийн сонирхлоос гадна Монгол Улсыг гадаад ертөнцөөс бүрэн тусгаарлах гэсэн геостратеги, геополитик зэрэгцэн явсан байна.

### Востваг хувьцаат нийгэмлэг, түүний үйл ажиллагаа

Монголын Засгийн газар ЗХУ-д үйлдвэрлэдэггүй машин, тоног төхөөрөмж болон аж үйлдвэрийн бараа, бусад өргөн хэрэглээний бүтээгдэхүүнийг гуравдагч зах зээлээс нийлүүлэх зорилгоор ганцхан Германы худалдааны томоохон хувьцаат нийгэмлэг /Акционерное Общество/ «АО Востваг»-ийн (**WOSTWAG-West-Osteuropaeische Warenaustausch Aktiengesellschaft-AG**: «Өрнөд-Дорнодын худалдаа, бараа солилцооны хувьцаат нийгэмлэг» гэсэн герман үгийн товчилсон нэр Д.У) Монголд явуулж байсан үйл ажиллагааг нь үргэлжлүүлэхээр зөвшөөрсөн байна.<sup>3</sup> АО «Востваг»-гүүсийн хувьцааны 25 «хувийг» ЗХУ эзэмшиж байсны гадна Монголд «уполномоченный фирм» гэсэн тодотголтой байжээ.

Энэ үед ЗХУ эдийн засгийн шинэ бодлогыг зарлан Өрнөдийн орнууд юуны өмнө Германтай худалдаа, эдийн засгийн харилцаагаа амжилттай хөгжүүлж эхлээд байсан юм.

**Востваг** нийгэмлэгийг 1923 онд Берлинд анхлан байгуулагдахад герман-латвийн жүүд ах дүү Абрам Лазаревич Эренльеб \*, Арон Лазаревич Эренльеб\* нар Зөвлөлтийн Ажилчин-Тариачны улаан армийн [РККА] IV газар буюу Цэргийн тагнуулын газрын тагнуулын сургуулийн дарга, гадаадын олон хэл эзэмшсэн Вальтер /Германович/ Кривицкий\* удирдлага дор /мөн Игнатий Рейсс\* (Игнасий Порецкий) оролцсон байдаг Д.У/ өөрсдийн хувь хөрөнгийг оруулж, үндэс суурийг нь хамт тавилцаж, удалгүй салбарыг нь Москвад нээжээ. Томоохон хэмжээний хувьцаат компани ногдол ашгаа байнга хуваарилдаг байв. Ах дүү хоёр 1926 онд Тяньзинд «Востваг»-ийн салбар компанийг байгуулахад оролцож, мөн Монголд 1928 он хүртэл ажиллажээ.

1923-39 оны хооронд үйл ажиллагаа явуулсан «Востваг» анх 100 мянган долларын дүрмийн сантайгаар үйл ажиллагаагаа эхэлж, үүнд Зөвлөлтийн хөрөнгө мөнгө оролцсон бөгөөд 1934 он гэхэд жилдээ 3,1 сая ам. долларын цэвэр ашиг олж, түүний тал хувь нь Германых байжээ.<sup>4</sup>

ЗХУ энэ компанийн халхавчаар өрнөдийн орнуудаас стратегийн зориулалттай орчин үеийн зэвсэг техникийн нарийн техник-технологи, тухайлбал шөнийн цагт нисэх онгоцны зүг чигийг нарийвчлан тогтоох навигацийн тоног төхөөрөмж, суманд тэсвэртэй хайлш, артиллерийн алсын тусгалын тоног, нисэх болон шумбагч онгоц, хүнд машин, механизмын хөдөлгүүр, стратегийн түүхий эдийг нууцаар худалдан авч байжээ. Мөн хууль бус худалдааны үйл ажиллагаа ч явуулж байжээ. Улаан армийн IV газар буюу Цэргийн

тагнуулын газрыг шууд удирдаж байсан Батлах хамгаалахын /Энэ үед БХЯ Цэрэг, тэнгисийн цэргийн ардын комиссариат нэртэй байв. Д.У/ ардын комиссар Климент Е.Ворошилов дээрх ажлыг 1926 оноос биечлэн хариуцаж Сталинд илтгэж байсан байна. Зөвхөн 1935 онд л гэхэд Ворошилов АНУ-аас цэргийн зориулалттай харилцаа холбооны технологи, оптикийн эд ангийг худалдаж авах талаар нууц гэрээ хэлцэл биечлэн хийж байжээ.<sup>5</sup> «Востваг» хувьцаат нийгэмлэг Улаан армийн IV газрын удирдлага дор хилийн чанадад байгуулагдсан анхны халхавч худалдааны сүлжээ компани байжээ.

1926 онд «Востваг» нийгэмлэг Хятадын худалдааны чухал төв-усан боомт хот Тяньзинд өөрийн салбар компанийг «Far Eastern Fur Trading Company» нэртэйгээр байгуулсан бөгөөд (зарим баримт бичигт «Trading & Engineering Co.,» (*Ostvag Co.*)) гэж тэмдэглэж байсан бөгөөд 1939 он хүртэл үйл ажиллагаа явуулжээ Д.У) эрхэлсэн түшмэлээр латвийн герман гаралт Адам Пурпис\* ажиллаж гол төлөв Хаалган, Тяньзинд байрлаж, үйл ажиллагаагаа явуулж, голдуу Гондурасын паспорт ашигладаг байжээ. Лондон, Парис, Нью-Йоркт тусгай ажлын шугамаар байнга ирж, очиж байсан байна. Адам Пурпис Өвөр Монголыг оролцуулан Монголоос жил бүр 30 мянган адууг Хаалган хотноо худалдаж, Хятадын армид нийлүүлж байжээ. Тиймээс Адам Пурписыг “King of Kalgan” хэмээн нэрлэж байв. Түүний хувийн жолооч нь урьд нь Панчин Богд, XIII Далай ламын жолоочоор ажиллаж байжээ.<sup>6</sup>

Түүний холбоо баригч Арнолд Дойч (Arnold Deutsch 1903-42?) нь австрийн герман, 24 насандаа Венийн их сургуулийн химийн салбарт докторын зэрэг хамгаалсан, Зөвлөлтийн ДЯЯ-ны туршуул байв. А.Дойч 1930-аад онд ДЯЯ-ны туршуулууд болох Кэмбрижийн гайхамшигт тавын нэг Ким Филбийн хамт Адам Пурпист тусладаг байжээ. Германд Гитлерийн нөлөө эрс хүчирхэгжиж, түүний аюулаас хамгаалах байгууллага «SS», «Востваг»-ийн үйл ажиллагааг тухайлан анхааралдаа авч эхэлсэн, Зөвлөлтийн ДЯЯ гадаад дахь төлөөлөгч-туршуулуудаа ихээхэн хардах болж, мөрдлөг шалгалт идэвхжиж, зарим нь баривчлагдан хэлмэгдэж эхэлсэн, зарим удирдлага Хятадад үйл ажиллагаа явуулж байхдаа Америкийн туг далбаа ашиглаж байсан байх бөгөөд Монгол, Хятадад ажиллаж байсан төлөөлөгчид хөрөнгө мөнгөө 1930-аад оны хоёрдугаар хагасаас Шанхайн салбараас Нью-Йорк дахь «Chase Manhattan Bank»-д шилжүүлж, АНУ-д дүрвэж гарсан байна. 1941 онд Адам Пурпис Нью-Йоркт алагдсан нь Холбооны мөрдөх товчоо энэ компаний явуулж байсан үйл ажиллагааны мөрөөр орж, мөрдөн

шалгаж эхлэх шалтгаан болжээ.

**«Востваг» -ийн Монгол дахь үйл ажиллагаа**

Ерөнхий хороо, төв оффис нь Берлинд, салбар нь Москва, Хаалган, Харбин, Мүгдэн, Тяньзин, Гуанжоу, Нью Йорк, Парис, Лондонд байрладаг «Востваг» компани Монголд «Wostwag-Urga Co.» 1923 оноос үйл ажиллагаагаа эхэлж, Монголоос мал, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, ноос, ноолуур, ангийн үс, адуу мал, эрдэс түүхий эдийг импортоор авч, машин тоног төхөөрөмж, бусад өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн нийлүүлж байв. 1923 оноос авто хөсгөөр Хаалган, нийслэл Хүрээний хооронд зорчигч-ачаа, тээврийн үйлчилгээ, худалдааны үйл ажиллагаа явуулж эхэлжээ.<sup>7</sup>

1923-26 онд Монгол дахь «Востваг» компанид С.М. Шпигельглас\* хэмээх ОГПУ-гийн туршуул халхавчаар анхлан ажиллаж эхэлжээ. 1928-38 онд «Wostwag-Urga Co.»-ийн Улаанбаатар дахь салбарын төлөөлөгчөөр Улаан армийн Цэргийн тагнуулын газрын /IV газар/ суурин төлөөлөгч резидент буюу товчлогч/ Дайн-Лундер Ян Юрьевич\* идэвхтэй ажиллаж эхэлжээ. Дайн-Лундер Улаан армийн IV газрын «Хилийн чанад дахь худалдааны хөдөлгөөнт сүлжээг удирдах газар»-ын дарга, дэслэгч генерал (корпусный комиссар) Стефан Иосифович Мрочковскийн\* шууд удирдлага дор ажиллаж байв. А.В.Сопронов\* хэмээх орос «Востваг» компанид үйлчилгээний ажилтнаар ажиллаж байжээ.

1925-27 онд Берлинд «Востваг» хувьцаат нийгэмлэг дэх Зөвлөлтийн Бүрэн эрхт төлөөлөгчөөр Д.Г.Евсеев\* ажиллаж байжээ. Тэрбээр 1927 оноос Берлин дэх ЗХУ-ын Худалдааны төлөөлөгчийн газрын хуучны үнэт эдлэл худалдаалахтай тэмцэх хэлтсийн эрхлэгчээр ажиллах болов.

«Востваг»-ийн талаарх илтгэлүүдийг БХК(б)Н-ын ТХ-ны УТТ-ны хурлаар үе үе авч хэлэлцдэг байжээ. Тус нийгэмлэгийн салбаруудад ажиллаж байсан Зөвлөлтийн Цэргийн тагнуулын газрын туршуулууд франц, герман, англи, голланд, итали, польш, хятад хэл чөлөөтэй эзэмшсэн, голдуу латви, литва, эстон, австри, польш гаралтай байсан байх бөгөөд тэд 1930-аад оны сүүлчээр бараг бүгд хэлмэгдсэн байна.

Цэргийн тагнуулын газрын удирдлага дор туршуулууд «Востваг»-аас гадна германы нисэх онгоц, дуран авиа үйлдвэрлэгч «К. Цайсс» (Carl-Zeiss-Stiftung), ган, суурь машин, хөдөлгүүрийн «Борзиг» (Borsig), цахилгаан хөдөлгүүр, эрчим хүч, инженер, зэвсгийн «АЭГ» (AEG-Allgemeine Elektrizitäts Gesellschaft-General Electric Co.), зөвлөлт-германы хамтарсан хувьцаат химийн зэвсэг

болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компани «Берсол» (joint stock company “Bersol”), зөвлөлтийн хувь оролцсон германы компани «Chemische Fabrik Stoltzenberg» (оросоор Метакхим), Францад үйл ажиллагаа явуулж байсан «Спакомер» (Spi commercio) зэрэг хувьцаат нийгэмлэгүүдэд ажиллаж байжээ. Улаан армийн тагнуулын газар бүр 1924 онд Нью Йоркт америкийн пүүс компанитай хамтарсан экспорт-импортын үйл ажиллагаа эрхлэх «Амторг» (Amtorg Trading Corporation) хувьцаат нийгэмлэгийг байгуулж, тус нийгэмлэг худалдаа, эдийн засгийн тагнуулын идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлжээ. 1933 онд АНУ-ын Ерөнхийлөгчөөр Ф.Рузвельт сонгогдон ЗХУ-ыг хүлээн зөвшөөрөхөд «Амторг» зохих хувь нэмрийг оруулсан хэмээн үнэлэгдэж, И.В.Сталин энэ хувьцаат нийгэмлэгийг 1934 онд “Байлдааны гавьяаны улаан туг”-ийн одонгоор шагнаж байсан байна.

Монгол Улсын Засгийн газар гадаад худалдаанд улсын монополь эрх тогтоосон байхад Германы Востваг хувьцаат нийгэмлэг 1930 оноос ганцаараа Монголд үйл ажиллагаагаа явуулах статусаа хадгалж үлдсэн нь Зөвлөлтийн тусгай албадын үйл ажиллагаатай шууд холбоотой байжээ.

1930 оноос «Востваг» компани БНМАУ-ын Засгийн газрын зөвшөөрлөөр Улаанбаатарт ажиллаж, Хоршоолын Төв Холбоо, Улсын худалдааны газрын хамтран боловсруулж, Худалдаа, Аж үйлдвэр, Тээвэр Харилцан Нэвтрэлцэх Холбооны ямаар батлагдсан захиалгын дагуу бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж байв. Тайлангаас харахад 1930 оноос «Востваг»-нь Монголын нийт гадаад худалдаанд монополь байж, олсон ашгийн 50 хувийг нь шууд Москва дахь Зөвлөлтийн төв банкад шилжүүлдэг байжээ. Мөн Монголын Ардын армийн зарим зэвсэг техникийг Германаас нийлүүлж байв.

«Востваг» компани Монголд оруулж ирэх өөрийн барааг үндсэнд нь хоёр чиглэлээр бэлтгэж байжээ. Үүнд: Герман дугуй, мотоцикл, зургийн аппарат, бичгийн машин, цаг, цахилгаан хэрэгсэл, эм, химийн бүтээгдэхүүн, бэлэн хувцас болон бусад жижиг бараа, Хятадад бэлтгэсэн торгон нэхмэл, үхрийн булигаар, илэг, сарьс, гөлөм, давс, ташуур, цай, тамхи, лааг Зөвлөлтийн төмөр замаар Алтанбулгийн дамжлагаар нэвтрүүлэн тээвэрлэн нийлүүлж байв.

Энэ компани Монголоос тарвага, үнэг, чоно, хэрэм, хярсны арьс зэрэг ангийн үс хонь, үхрийн арьс, шир, амьд адуу, ноос, ноолуур голлон бугийн эвэр, мөөг, хунчир зэрэг бусад түүхий эдийг өргөн хэмжээгээр гаргаж байжээ. 1923-37 онд «Востваг» компанийн Берлин дэх төвийн Ерөнхий захирал Давид Розенблэт (Dr.Da-

vid Rosenbliett 1939 онд АНУ-д дүрвэсэн), орлогч Леополд Вилде (Dr. Leopold Wilde 1939 онд АНУ-д дүрвэсэн), Хуго Вальдерк (Dr. Hugo Walderck) нарын 1930 оны 7 дугаар сард гаргасан 1928-29 оны тайлангаас харахад 1928 онд ЗХУ-тай хийсэн худалдаа 14.1 сая райхсмарк (RM-reichsmark 1924-48 онд хэрэглэгдэж байсан Д.У) байсан бол 1929 онд 5.3 сая болж буурсан нь 1929 оны 12 дугаар сарын 31-нд худалдаа хийх концессын хугацаа дуусгах гэж байсан холбоотой байжээ. Харин Монгол руу экспортолсон бараа 1.709 сая, импортоор авсан бараа RM 929 мянга болж байсан нь Хятадтай хийсэн худалдааны нийт эргэлт болох 713 мянган RM байснаас даруй 3 дахин их байв. Хятад болон өрнөд Европт бэлтгэн Монгол руу оруулж ирсэн бараа зөвхөн 1933 онд хилийн үнээр 1 сая 920, 4 мянган алтан рубль буюу жижиглэн худалдаалах үнээр 7 сая 622,2 мянган төгрөг байсан бол 1935-38 онд хилийн үнээр 3 сая 334,7 мянган алтан рублийн (Зөвлөлт засаг 1922-24 онд мөнгөний шинэтгэл хийж алтан баталгаат рублийг /Лениний хөрөгтэй/ анх гүйлгээнд гаргасан бөгөөд ханшаараа RM 1=10 алтан рубль болж байв Д.У) барааг оруулж ирж байсан байна.<sup>8</sup>

1931 онд «Востваг» компанийн Зүүн Ази руу хийсэн экспорт RM 4.092,400.22, импорт RM 370.626,52, Монгол-Хятадын хооронд хийсэн «Востваг»-ын худалдааны эргэлт RM 1.896.366,77, 1932 онд Зүүн Ази руу хийсэн экспорт RM 1.125.642,13, Монгол руу хийсэн экспорт RM 519.701,48, Монгол-Хятадын хооронд хийсэн «Востваг»-ын худалдааны эргэлт RM 1.723.642,74, 1933 онд Зүүн Ази руу хийсэн экспорт RM 1.067.671,19, Монголтэй хийсэн худалдааны эргэлт RM 793.135,95, Монгол-Хятадын хооронд хийсэн «Востваг»-ын худалдааны эргэлт RM 3.961.517,48, 1934 онд Зүүн Азид гаргасан экспорт RM 349.202,72, Монголтой хийсэн худалдааны эргэлт RM 240.596,77, Монгол-Хятадын хооронд хийсэн худалдаа 2.830.914,84, 1935 онд Зүүн Ази руу хийсэн экспорт RM 712.108,31, Монгол-Хятадын хооронд хийсэн «Востваг»-ын худалдааны эргэлт RM 5.002.483,52, 1936 онд Дорнод Азид гаргасан экспорт RM 1.391.401,26, Монгол-Хятадын хооронд хийсэн «Востваг»-ын худалдааны эргэлт RM 2.533.694,69, 1937 онд Монгол-Хятадын хооронд хийсэн «Востваг»-ын худалдааны эргэлт RM 3.780.713,20, Монгол-Хятадаас «Востваг»-ын бусад орнуудад хийсэн импорт RM 3.579.620,53 болсон байна.<sup>9</sup>

«Востваг» хувьцаат нийгэмлэгийн жил бүрийн тайлангийн тоо, баримтаас харахад Монгол Улсын гадаад худалдаанд тус нийгэмлэг маш том байр суурь эзэлж байсан нь харагдаж байна.

«Востваг»-компани нь мөн Америкийн «General Motors» корпорацийн distributor төлөөлөгчөөр ажиллахын сацуу Германы нэртэй, томоохон компани, үйлдвэрийн газар, тухайлбал: «Daimler-Mercedes-Benz», «H.A.G»-аас резинэн эдлэл, «Bosch»-оос автомашины сэлбэг, прожектор, машин, ундаг дугуй, чийдэн, «Opel»-оос унадаг дугуй, мотоцикль, автомашин, «Mercedes»-ээс бичгийн машин, «Mimosa»-аас фото цаас, фото хальс, фото аппарат «Siemens-Telefunken Gesellschaft für drahtlose Telegraphie mbH»-ээс цахилгаан бараа, холбооны хэрэгсэл зэргийг нийлүүлж байжээ.(80)8)

Мөн «Востваг» компани Хятадын Наньжоу-Юйшань-Наньчан-Писянь-Чучжоу чиглэлээр төмөр зам тавьж байсан Германы нэртэй томоохон компани болох «Otto Wolff & Co.», «Feinstein», «Opel», «Ferrestahl», «Friedrich Group», «Stahl Union Export Co.» зэрэгтэй хамтран ажиллаж байсан байна.

Германы «Востваг» худалдааны сүлжээ томоохон хувьцаат нийгэмлэгийн үйл ажиллагаанд Зөвлөлтийн тусгай албадын оролцоо хүчтэй байсан хэдий ч 1920-иод онд Монгол-Германы худалдааны харилцаа амжилттай, 1930-аад оноос зохих түвшинд хөгжиж, Монголын удирдагчид Герман улстай харилцаагаа худалдаа, соёлын салбарт хөгжүүлэх талаар бие даасан, идэвхтэй байр суурь баримталж байсныг онцлон тэмдэглэвэл зохино. Харин 1925-26 онд Германд нэжгээд удаа айлчилсан Цэдэн-Эшийн Дашсампилон тэргүүтэй худалдааны төлөөлөгчид, Эрдэнэбатхаан тэргүүтэй Гэгээрлийн яамны төлөөлөгчдийн үйл ажиллагаанд «Востваг» компаний оролцоо төдийлэн их биш юм.

Герман улс 1936 оны 4 дүгээр сарын 30-нд 1 жилийн хугацаатай, 1937 оны 5 дугаар сарын 21-нд 3 жилийн хугацаатай худалдааны хэлэлцээрийг Манж-Го-тай байгуулснаар «Востваг» компани Манжуурт өргөн хүрээтэй худалдааны үйл ажиллагаа явуулах болсон байна. Германд фашист дэглэм тогтож, олон улсын байдал хурцалсан хийгээд Герман нь 1938 оны 5 дугаар сарын 12-нд Манж-Го-г хүлээн зөвшөөрсөн, гучаад оны сүүлчээр хувьцаат нийгэмлэгийн удирдлагуудыг Зөвлөлтийн ДЯЯ мөрдөн мөшгиж, баривчлан хэлмэгдүүлж, зарим нь гадаад руу дүрвэн гарсан зэрэг олон хүчин зүйл, шалтгааны улмаас 1939 оны зун Сангийн Яамны шинээр томилогдоод удаагүй байсан залуу сайд Ю.Цэдэнбалын тушаалаар «Востваг» компанийн Монголд явуулж байсан үйл ажиллагааг нь зогсоожээ.<sup>10</sup>



### ДУГНЭЛТ:

XX зууны эхээр Германы Алс Дорнод дахь ашиг сонирхол өргөжиж, улмаар Монголд ч анхаарал тавьж эхэлжээ. Хоёр орны түрүү үеийн харилцааны түүхийн хамгийн оргил үе нь 1920-иод он байсан нь тодорхой байна. Тухайн үедээ Зөвлөлт, Хятадын 1924 оны хэлэлцээрийн заалтаас шалтгаалан Ваймерын Бүгд Найрамдах Улс нь БНМАУ-ын тусгаар тогтнолыг de facto хүлээн зөвшөөрөөгүй ч ad hoc хүлээн зөвшөөрч, худалдаа-эдийн засаг, соёл-боловсролын салбарт нэн сайн харилцаатай байсан гэж дүгнэж болохоор байна. Үүнд: «Востваг» компани тодорхой байр суурь эзэлнэ. Энэ нь Монгол-Герман хоёр улсын ирээдүйн найрсаг харилцаа хөгжихийн шимтэй хөрс болсон нь маргаангүй юм. Цаашид эл сэдвийг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай гэж үзэж байна.

### ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

<sup>1</sup> «Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Холбоот Улс ба БНМАУ хоёрын хоорондын үндсэн зүйлүүдийг батлан тогтоосон Гэрээ бичиг» ГХТА. Хөмрөг №19, Д. 1. ХН. 0212813 16

<sup>2</sup> Мөн тэнд. Гэрээ бичгийн 5 зүйл

<sup>3</sup> Hamburgisches Welt-Wirtschafts-Archiv. Wostwag-West-Osteuropaeische Warenaustausch Aktiengesellschaft-AG. B-R[00001-00009] (view)

<sup>4</sup> РГАЭ. Российский Государственный Архив Экономики. Центральное отделение Западно-Восточно-Европейского товарообменного АО «Востваг» для СССР и его ликвидационная комиссия. Ф.3670,

<sup>5</sup> The National Archives. UK Government official Archive, British Public Records Office. KV 2/1902 KV/1655 PF 45633 VOLS 1-2, Publicly released in 2004 & 2005

<sup>6</sup> РГВА. Российский Государственный Военный Архив. Ф. 33989, опись 3, дело. 599, л.46- 50, от К.Ворошилов к И.Сталину, январь 1935. №60

<sup>7</sup> Motor Deal with living God in Urga. "Asia" 1924. Уо1. 31. pp.232-238

<sup>8</sup> Hamburgisches Welt-Wirtschafts-Archiv. Wostwag-West-Osteuropaeische Warenaustausch Aktiengesellschaft-AG. B-R[00010-00018], Bericht des Vorstandes der 1929-1935

<sup>9</sup> Hamburgisches Welt-Wirtschafts-Archiv.[00019-00025]

<sup>10</sup> УТТА. Ф.289. Сангийн яамны данс. Воствагийн үдмэл хавтаст хэрэг. 1939 он

\* **Эренльеб, Абрам Лазаревич** (Abraham Ehrenlieb [1898-1938]) өөр нэр нь Антек Бронислав Яновский 1898 онд Болгарын Люлин хотод латви-германы жүүд гэр бүлд төржээ. 1916 онд ОАСД(б)Н-д элссэн. Ажилчин-Тариачны Улаан армийн [РККА] IV газар буюу Цэргийн тагнуулын газрын туршуул, 1936 онд хошууч [батальонный комиссар] цол хүртсэн. 1923 онд Берлинд халхавч «Востваг» худалдааны сүлжээ хувьцаат компанийг байгуулахад төрсөн Аарон Л.Эренльибийн хамт оролцсон. 1926 оноос Улаанбаатар дахь «Востваг»-ын салбар, Хятадын Тяньцзин, Хаалганд ажиллаж, 1930 оноос Европт ажиллаж, 1937 онд Москвад дуудагдан баривчлагдаж, 1938 онд хэлмэгдсэн. 1957 онд цагаатгасан.

\***Эренльеб, Арон Лазаревич** (Aaron Ehrenlieb [1897-1937]) өөр нэр нь Зигмунд Бронислав Яновский 1897 онд Минскт төрсөн, Абрам Лазаревич Эренльибийн төрсөн ах, латви үндэстэн. 1917 онд ОАСД(б)Н-д элссэн. 1923 онд Берлинд халхавч «Востваг» худалдааны сүлжээ хувьцаат компанийг байгуулахад дүү Абрам Л.Эренльибийн хамт оролцсон. Улаан армийн [РККА] IV газар буюу Цэргийн тагнуулын газрын туршуул, 1936 онд хошууч [батальонный комиссар] цол хүртсэн. 1922-25 онд Берлин дэх Зөвлөлтийн ЭСЯ-нд референт, 1925-28 онд төвд, 1928 онд В.Кривицкийн удирдлага дор тагнуулын сургуулын нэг жилийн дамжаа дүүргэсэн. 1928 оноос Улаанбаатарт «Востваг»-ийн төлөөлөгчийн газарт, дараа нь Герман, Австриг туршуулаар ажиллаж, 1937 онд Лондоноос Москвад дуудагдан баривчлагдаж хэлмэгдсэн. 1957 онд цагаатгасан.

\***Кривицкий, Вальтер Германович** (жинхэнэ нэр нь Samuel Gershevich Ginsberg 1899-1941) Австри-Унгарын эзэнт улсын үед Подволочыск хотод худалдааны албан хаагчийн жүүд гэр бүлд төрсөн, 1941 оны 2-р сарын 10-нд Вашингтонд Зөвлөлтийн ДЯЯ-ныхны гарт алагдсан. Баруун Европ дахь Зөвлөлтийн Цэргийн тагнуулын сүлжээний удирдагч. Львовт гимнази дүүргэсэн. Орос, герман, франц, польш, унгар, итали, голланд зэрэг олон хэл эзэмшсэн. 1919 онд БХК(б)Н-д элсч, 1935 онд аюулаас хамгаалах байгууллагын бригадын комиссар цол хүртсэн (улаан армийн хошууч генерал цолтой дүйнэ), Өрнөдөд түүнийг генерал гэж дууддаг. 1919-21 онд Австри, Польшид Коминтерний туршуулаар хууль бус үйл ажиллагаа явуулж байсан. 1921-31 онд Улаан армийн Цэргийн тагнуулын газрын гүйцэтгэх ажиллагааны албыг Ян Карлович Берзины дор удирдаж, 1923 онд Цэргийн Академийн дээд дамжаа дүүргэсэн. 1923-26 онд Бригад командлагчийн албан

тушаалд Гадаадад ажиллах туршуулуудыг бэлтгэх ажлыг зохион байгуулж, Цэргийн тагнуулын сургуулийг удирдаж байсан. 1926 онд Германд томилолтоор ажиллаж байв. 1931 онд Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор шагнагдсан. 1933-34 онд Цэргийн аж үйлдвэрийн институтийн захирлаар генералын зэрэгтэй тушаалд ажиллаж Өрнөд Европ, Америкийн цэргийн технологи судлах, олж авах асуудалд анхаарлаа хандуулж байв. 1935-36 онд Голланд, Швейцари, Австри, Герман, Францад суурин төлөөлөгчөөр ажиллаж, Герман-Японы хооронд явагдаж байсан нууц хэлэлцээнүүдийн талаарх бүрэн мэдээллийг эх сурвалжаас нь буюу Берлин дэх Японы элчин сайд Хироши Ошима болон цэргийн атташе нараас олж төвд мэдээлж байжээ. 1936 оны 12 дугаар сард Кривицкий Герман дахь Зөвлөлтийн тагнуулын бүх сүлжээг «царцаах» Төвийн тушаал гэнэт хүлээн авсан нь Сталин Гитлертэй өөрийн хувийн сувгаар яриа хэлэлцээ эхлүүлж байсантай холбоотой байв. Ийм нөхцөл байдлын дунд 1937 оны 3 дугаар сард Кривицкий Москвад яаралтай дуудагдан иржээ. Түүнийг ирэх үед Цэргийн тагнуулын газар, ДХАК-ын Улсыг аюулаас хамгаалах газрын Гадаад хэлтсийн аппаратад өргөн хэмжээний баривчилгаа явагдаж байжээ. Өөрийг нь баривчлах асуудал шийдэгдэж байгаа тухай ДХАК-ын 1 дүгээр орлогч, Улсыг аюулаас хамгаалах Ерөнхий газрын дарга М.П.Фриновскийгээс баттай мэдээлэл авсны дараа Зөвлөлт-Финландын хилээр нууцаар яаравчлан гарч, 1937 оны 5 дугаар сарын 23-нд Голландын Хаагад иржээ. Кривицкийг Игнатий Рейссийг устгах ажиллагаанд оролцохыг санал болгоход тэрбээр татгалзсан байна. 1937 оны намар түүнийг Москвад яаралтай дуудахад ЗХУ-д юу болж буйг сайтар мэдэх болсон тул татгалзжээ. Кривицкий Францийн Засгийн газраас улс төрийн оргонол хүсч, 1937-38 онд Парист амьдарч байгаад 1938 оны 12 дугаар сард АНУ-д дүрвэн гарчээ. Тэрбээр Холбооны Мөрдөх Товчоонд Зөвлөлтийн тусгай албадын Европ, АНУ-д явуулж буй бусармаг үйл ажиллагааны талаар мэдээлж, хамтран ажиллах санал тавьсан боловч цаадуул нь төдийлөн өндөр ач холбогдол өгөөгүй ажээ. Тэрбээр 1911 онд Оросоос АНУ-д цагаачилсан The New York Herald Tribune сонины сэтгүүлч Исаак (Isaac Don Levine 1892-1981)-тай холбогдон түүний тусалцаатайгаар 1939 онд Saturday Evening Post сонинд Сталины харгис дэглэмийн үнэн нүүр царайг илчилсэн цуврал өгүүллүүдээ нийтлүүлж, мөн ондоо багтааж тэдгээрийг нэгтгэж, засварлан Нью Йоркт "In Stalin Secret Service: An Expose of Russia's Secret Policies by the Former Chief of the Soviet Intelligence in Western Europe"

нэртэй 340 хуудас бүхий томоохон хэмжээний номоо хэвлүүлж чадсан байна. Энэ ном 1991 онд ЗХУ-д “Я был агентом Сталина: Записки советского разведки” нэртэйгээр хэвлэгдэн гарчээ. Мөн тэрбээр Төрийн департаментад хандаж мэдээлэл, мэдүүлэг өгсөн боловч аанай л Их Британид хандахыг санал болгожээ. Чингээд 1940 оны 1 дүгээр сард Лондонд ирж, Британийн Аюулгүй Байдлын Алба MI5 (Military Intelligence, Section 5)-ийн дарга Жейн Арчерт гэрчийн мэдүүлэг өгч Европт ажиллаж буй Зөвлөлтийн 100 илүү гаруй туршуул, тагнуулуудын нэрсийг өгсөн байна. Кривицкий удалгүй Канадаар дамжин АНУ руу буцжээ. Тэрбээр 1941 оны 2 дугаар сарын 10-нд Вашингтонд Bellevue зочид буудалд өглөөний 9.30-ын орчимд өрөөндөө амиа хорлосон байдалтай баруун гартаа 38 мм-ийн калибр револьвер гар буу атгаад учир битүүлэг алагдсан байна. Түүний үхлийн шалтгаан олон жил маргаантай байсан ч 1990 онд КГБ-гээс сайн дураар халагдан сэтгүүлчээр ажиллах болсон экс офицер Александр Васильев 2009 онд америкийн судлаач Хейнс, Клер (Haynes J. E., Klehr H.) нартай хамтран бичиж, Йелийн их сургуулиас эрхлэн хэвлүүлсэн “Spies: The Rise and Fall of the KGB in America” 650 хуудас томоохон бүтээлдээ: КГБ-гийн архивын шинэ баримтыг дэлгэн тавьсан юм. Түүнд: 1941 оны 4 дүгээр сарын 11-нд Москва дахь ДХАК-тын Гадаад тагнуулын албаны төв байранд Улсыг аюулаас хамгаалахын дэслэгч Бутковоос ДХАК-тын 1 дүгээр Газрын 3 дугаар хэлтсийн дарга, хошууч Прудниковт “Урван зугтагч Кривицкийг устгасан гүйцэтгэх ажиллагааны талаарх илтгэл”-ийг танилцуулсан баримтыг иш татсан байна. В.Г.Кривицкийг бүр 1956 онд цагаатгасан байна.

**\*Рейсс, Игнатий Станиславович** (жинхэнэ нэр нь Натан Маркович Порешкий 1899-1937) тэрбээр Австри-Унгарын Подволочиск хэмээх сууринд жүүд гэр бүлд төржээ. Дунд боловсролыг Львовт ахтайгаа хамт олж авсан бөгөөд Вений их сургуулийн хуулийн факультетэд суралцаж төгсчээ. Дэлхийн I дайны үед Лайпцигт шилжин амьдарч, германы социалистуудтай танилцаж, 1918 онд нутагтаа ирж төмөр замд түр ажиллажээ. Ах нь 1920 онд зөвлөлт-польшийн дайны үеэр алагдсан байна. 1919 онд Польшид коммунист хөдөлгөөнд идэвхтэй оролцож, Коминтернид ажиллаж байв. 1920 онд Москвад ирж гэр бүлтэй болж, БХК(б)Н-д элсч, удалгүй ВЧК-гийн ажилтан болжээ. 1920-22 онд Львовт хууль бус хувьсгалт утга зохиол тарааж түгээх ажил эрхэлж байгаад баривчлагдан 5 жилийн ял сонсчээ. Тэндээсээ оргон зайлж, Германд иржээ. 1922-29 онд Берлин, Вена, Амстердамд ажиллаж, энэ үеэр

хууль бус тагнуулын үйл ажиллагаа явуулж байсан Я.Блюмки, В.Зарубин, Ш.Радолон Ян Берзин нартай холбоотой ажиллаж байв. Берлинд «Востваг» компанийг байгуулахад үүрэгтэй оролцсон. 1927 онд Британид тагнуулын сүлжээ байгуулсныхаа төлөө Улаан тугийн одонгоор шагнагдсан. 1929-32 онд Москвад Коминтерний Польшийн секторт ажиллаж, дараа нь 1932-37 он хүртэл Парист суурилсан хөдөлгөөнт тагнуулын сүлжээнд ажиллаж байв. 1937 оны 7 дугаар сард Рейссийг Москвад дуудахад ЗХУ-д болж буй үйл явдлын талаар сайтар мэдээлэлтэй байсан учир татгалзсан байна. 1937 оны 7 дугаар сарын 17-нд Францын сонинуудад Сталиныг шүүмжилсэн түүний нээлттэй захидал хэвлэгджээ. Түүнд “Зөвхөн социализмын ялалт хүн төрөлхтнийг капитализмаас, ЗХУ-ыг сталинизмаас чөлөөлнө” гэж бичсэн байна. Үүний дараа тэрбээр эхнэр хүүхдийн хамт Швейцарийн эртний нэгэн тосгон Финот Валед хэдэн сар амьдарчээ. Тэгээд 9 дүгээр сарын 4-нд нэгэн үе Лайпцигийн эртний сайн танил Элизабет Шильбактай Лозаннид уулзахаар тохиролцоод явжээ. Харин Рейссийн эхнэр нь 9 дүгээр сарын 6-ны сониноос 9 дүгээр сарын 4-ний шөнө Швейцарийн Лозаннаас Пулли орох замд чехословакийн паспорттай Ханс Эберхард гэх эрэгтэй хүний цогцос олдсон болохыг мэджээ. Энэ нь И.С.Рейссийн цогцос байжээ. ДЯЯ-ны туршуул С.М.Шпигельгласын удирдлага дор Москвагаас ирсэн тусгай групп тухайлан Борис Афанасьев И.С.Рейссийн амийг бүрэлгэсэн байна. 1960 онд И.С.Рейссийг цагаатгажээ.

\***Adam Purpiss** (1883-1941) Латвид төрсөн жүүд. Цэргийн тагнуулын газар, Коминтернд элсэгдсэн туршуул. 1941 онд Нью-Йоркт Зөвлөлтийн ДЯЯ-ныханд алагдсан.

\***Шпигельглас, Сергей Михайлович** (1897-1941) ВЧК, ОГПУ, ДЯЯ-ны ажилтан, аюулаас хамгаалахын батальоны комиссар (армийн хурандаа цолтой дүйнэ) цолтой. Оператив ажиллагааны нууц нэр нь «Дуглас». Белорусын Мосты Гродненский хотод нягтлан бодогч германы жүүд гэр бүлд төржээ. Варшавт дунд сургууль дүүргээд Москвагийн улсын их сургуулийн хуулийн салбарт суралцсан. 1917 онд 3 дугаар дамжаанаас цэрэгт татагдан Петроградад бага даргын сургууль төгсч, 42 дугаар нөөцийн суманд алба хаажээ. Октябрийн хувьсгалын дараа Цэргийн хяналтын газарт ажиллаж, 1918 онд ОК(б)Н-д элссэн. 1920 оны 2 дугаар сард ВЧК, 1922 оноос ОГПУ-ын Гадаад хэлтсийн ажилтан, 1923-26 онд Улаанбаатарт «Востваг»-ийн төлөөлөгч, дараа нь Францад хууль бус тагнуулийн үйл ажиллагаа явуулж байв. 1935-36 онд ДХАК-тын УАХЕГ-ын Гадаад [тагнуулын] хэлтсийн орлогч дарга, түүнийг

энэ албан тушаалд ажиллаж байхад 1938 оны 2 дугаар сард Гадаад хэлтсийн дарга А.А.Слуцкий «гэнэт» нас барьж, удалгүй оронд нь С.М.Шпигельглас томилогдсон байна. Тэрбээр тагнуулчдыг гардан бэлтгэж байсны дотор Авенир Беннигсен зүй ёсоор ордог. Мөн нэг биш удаа алан хядах ажиллагааг гардан удирдаж хэрэгжүүлсэн. Үүнд: 1937 оны 9 дүгээр сард Швейцарит ДХАК-ын туршуул Игнатий Рейссийг, мөн сарын 22-нд Парист Оросын [Хаант] Ерөнхий цэргийн холбооны дарга агсан, генерал Е.К.Миллер, 1937 онд Францад гарсан ДХАК-тын Дорнодын секторын дарга Георгий Агабеков, 1938 оны 5 дугаар сард Роттердамд Украины үндсэрхэх үзэлтний удирдагч Е.Коновальц, 1938 оны 7 дугаар сард IV Интернационалын удирдагчдын нэг Рудольф Клемент нарыг устгасан ажиллагаанууд ордог. 1938 оны намар баривчлагдаж, 1941 оны 1 дүгээр сард дээд хэмжээгээр шийтгэгдсэн. 1956 онд цагаатгагдсан байна.

**\*Дайн-Лундер Ян Юрьевич** (Кристьянович 1895-1940) Латвийн Лифлянд мужийн (губерн) Вольмарын хошууны (уезд) Крустул хэмээх эдлэн газарт герман гаралтай гэр бүлд төрсөн. 1912 оны ОАСД(б)Н-ын гишүүн, 1917-20 онд Латвийн V буудлагын хорооны цэргийн комиссар, 1921-23 онд Ажилчин-Тариачны Улаан армийн Штабын Захиргаа-аж ахуйн хэлтсийн хангамжийн тасагт цэргийн комиссар, 1923-28 онд Москва болон Ленинградын Цэргийн тойрог дахь Улаан армийн Цэргийн тагнуулын тасгийн захиргаанд цэргийн комиссар, 1928-38 онд БНМАУ-д «Востваг» компанийн Бүрэн эрхт төлөөлөгч, 1935 онд хурандаа (полковой комиссар) цол хүртсэн. 1938.07.17-нд Улаан армиас халагдсан, Улаанбаатарт оршин сууж байгаад 1939.06.06-нд хувьсгалын эсэргүү байгууллагын туршуул гэсэн хилст хэрэгт баривчлагдан, 1940.08.24-нд буудан хороогдсон, 1957 онд цагаатгасан байна.

**\*Мрочковский, Стефан Иосифович** (1885-1967) Елисаветград буюу өнөөгийн Украины Кировоградд төрсөн. Гадаадын олон хэл эзэмшсэн. 1905 оны ОАСД(б)Н-ын гишүүн, Харьковын их сургуулийн хуулийн факультетийг бүрэн хөтөлбөрөөр дүүргээд өмгөөлөгчөөр ажиллаж, Елисаветград, Кисловодск болон Харьковын боловсролын байгууллагуудад ухуулагч, үзэл суртлын эрхлэгчээр ажиллаж байв. 1921-25 онд ГХАК-д «ЗХУ, Польшийн хилийн будлианыг зохицуулах, иргэд нүүлгэн шилжүүлэх Риган гэрээг хэрэгжүүлэх Олон улсын тусгай комиссо»-ын Зөвлөлтийн төлөөлөгчдийн орлогч дарга, Улаан армийн Цэргийн тагнуулын газрын халхавч «Берсоль», «Метахим» хувьцаат нийгэмлэгийн

Удирдах Зөвлөлийн гишүүн, дарга, 1925-27 онд Зөвлөлт-Германы цэргийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн Хариуцлагатай нарийн бичгийн дарга, 1928-39 онд Улаан армийн IV газрын "Хилийн чанад дахь худалдааны хөдөлгөөнт сүлжээг удирдах газар"-ын дарга [халхавч байгууллагууд Д.У], 1935 онд дэслэгч генерал (корпусный комиссар) цол хүртсэн, 1939-41 онд «Востваг» нийгэмлэгийн худалдааны олон улсын сүлжээний удирдагчаар Европт, Алс Дорнод, АНУ, Канадад ажиллаж байгаад 1942 онд ЗХУ-д дуудагдсан, 1943.01.18-нд баривчлагдан батлан хамгаалах салбарт хатуу хяналтад ажиллаж, бүр хойно есөн жилийн дараа буюу 1952.08.26-нд Цэргийн коллегийн Дээд Шүүхээс 15 жилийн ял сонсч, И.Сталин нас барж, Л.Барияг илчилсний дараа 1953.08.20-нд суллагдаж, бүрэн цагаатгагдан тусгай тэтгэвэр гарчээ.

\***Сопронов, Алексей Васильевич** 1877 онд Астрахан мужийн Ахтубинск [өнөөгийн] хотод төрсөн. «Востваг» компанид ачигч, үйлчлэгчээр ажиллаж байжээ. 1931 оны 8 дугаар сарын 22-нд Зөвлөлт засгийн эсрэг ухуулга хийсэн хэргээр ял сонсч, Зөвлөлт Казахстанд 3 жил цөллөгдсөн байна. 1989 онд цагаатгагдсан байна.

\***Евсеев, Дмитрий Гаврилович** (1892-1942) 1910 оны ОАСД(б)Н-ын гишүүн. Пензад төрсөн. Хувьсгалт үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байсан учир 1915 онд баривчлагдан 1917 онд хүртэл Сибирьт цөллөгт байжээ. 1917 онд ВЧК-д орж, Хойд фронтод отрядын дарга, 1918 оноос ВЧК-гийн эрүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн эрхлэгч, 1918-20 онд Улаан армийн цэргийн академид суралцсан. 1920-21 онд Нөөц армийн Штабын даргын туслах, 1921-22 онд Цэргийн академид үргэлжлэн суралцаж төгсчээ. 1922-23 онд Москва мужийн цэргийн тойрогт ВЧК-гийн төлөөлөгч, 1923 оноос Улаан армийн Цэргийн тагнуулын газарт, дараа нь Берлинд "Востваг" болон Худалдааны төлөөлөгчийн газарт ажиллаж байжээ. 1930-аад онд цэргийн аж үйлдвэрийн газруудад ажиллаж байгаад 1942 онд Ташкентад хүнд өвчний учир нас баржээ.

**Abstract:**

In this article has been researched the German (In 1918-33 the official name of Germany was the Weimer Republic D. U.) 'Wostwag' stock company, which had operated in Mongolia between 1920-1930s, about its activities, and how had participated the Ministry of Security Affairs of the Soviet Union in activities of the company. Moreover, here has been underlined the stock company's impacts on Mongolian foreign trade, economy and what happened in further destiny of Wostwag.

**Key words:** WOSTWAG-West-Osteuropaeische Warenaustausch Aktiengesellschaft-AG, stock company, dividend, foreign trade, trade representative, mobile trade network, Reichsmark, golden ruble, 4th department of red army, military intelligence agency, special services, de facto and ad hoc